



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

11.02 - 11.06



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Хэдийгээр Мягмарт гарагт болсон АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн тодорхойгүй байсан ч энэ долоо хоногийн Баасан гараг гэхэд АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 4-р сараас хойших хамгийн их өсөлт үзүүлэн хаагджээ. АНУ-ын Дэд Ерөнхийлөгч асан ноён Жо Байден Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан ч Бүгд найрамдах нам сенатын хяналтаа хадгалж үлдэх магадлал өндөр байгаатай холбоотой хөрөнгө оруулагчид хамгийн ашигтай нөхцөл байдлыг буюу Ардчилсан нам эдийн засгийн дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж чадах ч татварын хэмжээг тийм ч их хэмжээгээр нэмэгдүүлж чадахгүй гэсэн хүлээлттэй болсон байна.

Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс болон small-cap Russell 2000 индекс зах зээлийн үнэлгээ өндөртэй S&P 500 индексээс өндөр өсөлт үзүүлсэн байна. Хэдийгээр S&P 500 индексийн сагсанд багтах компаниуд 3-р улирлын тайлангаа нийтэлсэн завгүй долоо хоног байсан ч улс төр болон эдийн засгийн нөхцөл байдал зах зээлд илүү нөлөөтэй байлаа.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ-ын хөрөнгийн зах зээлийн өсөлт, компаниудын 3-р улирлын санхүүгийн тайлангууд хүлээлтээс илүү гарсан болон Их Британи улсаас эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ гэдгээ зарласантай холбоотой энэ долоо хоногт уналттай хаагдлаа. STOXX Europe 600 индекс 7.02%-аар, DAX индекс 7.99%-аар, CAC 40 индекс 7.98%-аар, FTSE MIB индекс 9.69%-аар, FTSE 100 индекс 5.97%-аар тус тус өссөн байна.

Евробүсийн голлох бондын өгөөж савлагаа ихтэй байсан ч долоо хоногийн сүүл үе гэхэд өмнөх долоо хоногийн түвшинтэй ойролцоо хаагджээ. ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж Лхагва гарагт АНУ-ын сонгуулийн үр дүн тодорхойгүй байсантай холбоотой унасан ч долоо хоногийн сүүл үеэр эргэн өссөн байна. Мөн хөрөнгө оруулагчид сонгуулийн тодорхойгүй байдал буурсантай холбоотой илүү эрсдэлтэй бондуудад хөрөнгө оруулж эхэлсэн нь Итали улсын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж буурахад нөлөөлжээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Мягмар гарагт амралтын өдөр тохиосонтой холбоотой хөрөнгийн зах зээл хаалттай байлаа. Nikkei 225 индекс 1,348 нэгжээр буюу 5.87%-аар өсөж 24,325.23 нэгж хүрсэн нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 2.8%-аар өссөн үзүүлэлт болсон байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд өсөлттэй байсан ч 2020 оны эхэн үеэсээ бага түвшинд байна. Энэхүү өсөлт нь компаниудын санхүүгийн үзүүлэлтүүд болон БНХАУ-ын үйлдвэрлэлийн хэмжээ эерэг байгаатай холбоотой.

БНХАУ: АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд АНУ болон БНХАУ-ын хоорондын харилцаанд эергээр нөлөөлөх хүлээлттэй байгаатай холбоотой энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Shanghai Composite индекс 2.2%-аар, large-cap CSI индекс 3.4%-аар тус тус өссөн байна. Мөн тус улсын эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгаатай холбоотой БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 3.22% хүрж нэмэгдсэн байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,517.07	0.64% ▲
Dow Jones	АНУ	28,323.40	6.87% ▲
S&P 500	АНУ	3,509.44	7.32% ▲
Nasdaq	АНУ	11,895.23	9.01% ▲
S&P/TSX	Канад	16,282.83	4.51% ▲
FTSE 100	Их Британи	5,910.02	5.97% ▲
S&P/ASX 200	Австрали	6,190.20	4.43% ▲
Nikkei 225	Япон	24,325.23	5.87% ▲
Hang Seng	Хонг Конг	25,712.97	6.66% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.86%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.51%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.42%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.65%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.09%
DBM' 2023	USD	7.250%	5.17%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	11.04%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	4.22%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.128	-0.09 ▼
Libor 3M	0.206	-0.05 ▼
Libor 6M	0.243	0.01 ▲
Libor 1YR	0.333	0.01 ▲
US 2YR Bond	0.151	-0.01 ▼
US 3YR Bond	0.195	0.02 ▲
US 5YR Bond	0.356	-0.05 ▼
US 10YR Bond	0.814	-0.05 ▼

Валютын ханш	2020.11.06	Өөрчлөлт
USD	2,849.83	-0.08% ▼
CNY	430.24	1.02% ▲
EUR	3,374.20	1.33% ▲
RUB	36.93	2.73% ▲
KRW	2.54	1.20% ▲
JPY	27.55	0.80% ▲
CAD	2,182.11	2.01% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,951.35	3.86% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	25.61	8.26% ▲
Зэс	USD/lb.	315.40	3.49% ▲
Нүүрс	USD/MT	62.47	5.58% ▲
WTI газрын тос	USD/bbl.	37.14	3.77% ▲
Brent газрын тос	USD/bbl.	39.45	5.31% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.IX	1.70%
Бодлогын хүү	2020.IX	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.IX	8.22%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	10.75%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.IX	3.76%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.IX	10.46%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 53 компанийн 570.2 сая төгрөгийн 3,010,660 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Бодь даатгал” /MSE: BODI/ компанийн хувьцаа 17.97%-аар буюу хамгийн ихээр өсөж 135.00 төгрөг хүрч хаагдсан бол “Техник импорт” /MSE: TEX/ компанийн хувьцаа 14.34%-аар буурч 6,900.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 11.7 сая төгрөгийн 114 ширхэг үнэт цаас арилжаалагдав.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 06-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,589.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,517.07 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.64% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	581.8	
Зах зээлийн үнэлгээ	2,589,653.7	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,517.07	0.64% ▲
MSE I индекс	8,022.16	0.61% ▲
MSE II индекс	7,346.48	1.14% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Монгол шуудан	359,920	233,288,991
Ард санхүүгийн нэгдэл	42,998	59,234,687
АПУ	92,324	53,227,334
Мандал даатгал	783,570	36,611,079
Үндэсний хувьчлалын сан	260,728	28,312,793

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Бодь даатгал	135.00	17.97% ▲
Шинэст	115.00	15.00% ▲
Монгол алт	6,325.00	15.00% ▲
Увс чацаргана	334.00	15.00% ▲
Мандал даатгал	48.00	9.31% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Техник импорт	6,900.00	-14.34% ▼
Монголын хөгжил үндэсний нэгдэл	3,250.00	-12.16% ▼
Мүдикс	6,900.00	-11.54% ▼
Хөвсгөл алтан дуулга	616.00	-7.64% ▼
Хөвсгөл алтан дуулга	20,500.00	-6.73% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	723,007,868
БиДиСек	102,730,800
Новел Инвестмент	34,107,893
Стандарт Инвестмент	33,212,512
Бумбат-Алтай	33,082,971

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	580.00	617,225.30
Таван толгой	5,795.00	305,194.83
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвескор ББСБ	2,927.00	209,947.62
Говь	193.00	150,561.71

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	114	11,650,000	102,500	100,000	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-нд ОЛГОВ
14	DSS	ДАРХАНСЭЛЭНГИЙНЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-нд ОЛГОВ
36	APU	АПУ	41,168.2	39,861.6	96.8%	37.5	2020.09.02	2020.11.02-нд ОЛГОВ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа нийт 42 компанид 2020 оны 12-р сарын 01-ний дотор журмаар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө ирүүлэх талаар хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн.

Энэхүү заасан хугацаанд МХБ-д хариу ирүүлээгүй, холбогдох зөрчлийг арилгаагүй компаниудыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авах тул холбогдох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, журмын шалгуур, шаардлагыг хангаж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс тус компаниудад дахин анхааруулж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Монгол базальт” /MSE: MBW/ ХК татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан ирүүлээ.

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Монгол Базальт” /MSE: MBW/ ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2020 оны 3-р улирлын байдлаарх зарцуулалтын тайланг ирүүлээ. Тус тайланд дурдсанаар нийт 5.96 тэрбум төгрөгийг доорх байдлаар зарцуулсан байна. Үүнд:

- Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл- 2.5 тэрбум төгрөг;
- Цахилгаан дэд станц-1.1 тэрбум төгрөг;
- Үйлдвэрийн барилга- 680.0 сая төгрөг;
- Үйлдвэрт ашиглах машин механизм- 330 сая төгрөг;
- Базальт карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж- 40.1 сая төгрөг;
- Базальт карьерийн аж ахуйн машин механизм- 210 сая төгрөг;
- Түүхий эдийн 4 сарын нөөц- 599 сая төгрөг;
- Урт хугацаат зээлийн эргэн төлөлт- 496.5 сая төгрөг.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Түмэн шувуут” /MSE: TUM/ ХК хувьцаатай өндөг хөтөлбөр хэрэгжүүлнэ

“Түмэн шувуут” /MSE: TUM/ ХК хэрэглэгчиддээ зориулж “Хувьцаатай өндөг” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээ олон нийтэд зарлалаа.

Уг хөтөлбөрт “Сувиллын өндөг” нэрийн бүтээгдэхүүнийг худалдан авсан хүн бүр хамрагдах боломжтой. Худалдан авагч E-CODE аппликейшн татаж ашигласнаар өндөг бүрт 5 төгрөгийн үнэ цэнэ (egg point) хуримтлагдаж, хуримтлалын дүнтэй дүйцэх “Түмэн шувуут” /MSE: TUM/ ХК-ийн хувьцаа олгогдох юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD; MSE: ERDN/ ХК Канадын Экспорт хөгжлийн агентлагтай санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурлаа.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD; MSE: ERDN/ ХК нь Канадын Экспорт хөгжлийн агентлаг (EDC)-тай Монгол Улсын баруун өмнөд бүсэд орших Баян Хөндий алтны төслийн хөгжүүлэлтийн хүрээнд 55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичиг (“Mandate letter”)–т гарын үсэг зурлаа.

Компанийн ерөнхийлөгч ба Гүйцэтгэх Захирал Петер Акерли хэлэхдээ: “EDC-тэй хамтран баталгаажуулсан зээлийн санхүүжилтийн баримт бичиг нь Баян Хөндий алтны төслийн хөгжилд нэгэн чухал ахиц боллоо. EDC нь Монгол болон олон улсад уул уурхайн төслүүдийг дэмжсээр ирсэн байгууллага. EDC болон манай томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартыг хамгийн өндөр түвшинд байлгаж, Монголын болон олон улсын нийт оролцогч талуудын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж хэллээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Монос хүнс” /MSE: MFC/ ХК татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан ирүүлээ.

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 8.58 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Монос хүнс” /MSE: MFC/ ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2020 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаарх зарцуулалтын тайланг ирүүлээ. Тус тайланд дурдсанаар нийт 8.02 тэрбум төгрөгийг доорх байдлаар зарцуулсан байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн барилгын өргөтгөл -2.4 тэрбум төгрөг;
- Тоног төхөөрөмж, тээвэр хэрэсэл, тавилга -4.3 тэрбум төгрөг;
- Эргэлтийн хөрөнгө - 874.1 сая төгрөг;
- Шинэ технологид хөрөнгө оруулах - 365.1 сая төгрөг;

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

АНУ-ын Элчин сайдын яам Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд шинжилгээ хийж тайлан гаргаад байна. Үүнээс цар тахлын нөлөө болон Олон Улсын Валютын Сантай хамтран хэрэгжүүлсэн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хийсэн шинжилгээ анхаарал татаж байна. Тус тайланд Монголын улс төрийн нөлөө их байдаг уул уурхайн салбарт хөрөнгө оруулах нь илүү эрсдэл өндөртэйг тодотгожээ. Цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 39%-ийг бүрдүүлдэг үйлчилгээний салбар хамгийн их хохирсон юм. Хэдийгээр оны 2-р хагаст “V” хэлбэрийн сэргэлт гарахаар байгаа ч жилийн дүнгээрээ агших төлөвтэй байна. Хэдий тийм боловч уул уурхай, хөдөө аж ахуйн салбар тогтвортой байгаа учир бусад ижил орнуудтай харьцуулахад хохирол багатайгаар цар тахлыг даван туулах боломжтой гэж АНУ-ын Элчин сайдын яамны тайланд дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ



УИХ-ын 2020 оны 11-р сарын 5-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг эцсийн хэлэлцүүлгээр хэлэлцүүлж баталлаа.

Ирэх онд Монголбанк зээлийн хүү бууруулах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх, санхүүгийн хэрэглэгчийг зайнаас танихтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулахтай холбоотой олон ажлыг хийхээр төлөвлөж байна.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанк 2020 оны 10-р сард 2.1 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 19.2 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.3 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 19.2 тн үнэт металлын 17.5 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 10-р сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 102.1 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 114.6 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 1.6 тн үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 10-р сард 174,145.46 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.